

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/13-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.mn">bolort@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	22-25
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	26-31
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	32-33

## **Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНС	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ТҮШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г.БАТБОЛД ТАНАА

2024.03.25 № СЭА-2024/13-НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 11,653.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сумын ИТХ-ын “Түшиг сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 89 дүгээр тогтоолоор тайлант онд 427,836.6 мянган төгрөгийн татварын орлого, 16,000.0

мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **443,836.6** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **965,536.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.1 дахин давуулан биелүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

“Дархан - Сэлэнгийн авто замаас Түшиг – Зүүнбүрэн – Цагааннуур – Түшиг - Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл 2 хэсэг” тайлант онд Түшиг сумын нутагт авто замын ажил явагдаж, замын хучилт, далангийн ажилд хэрэглэгдэх хайрга ашигласны төлбөрт 269,730.0 мянган төгрөг, авто замын ажил гүйцэтгэж буй “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ийн байгаль орчинд учруулсан хохиролд тавигдсан нөхөн төлбөрийн актаар 69,676.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Түшиг сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 225 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.2 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## **2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

<b>Код:</b>	<b>Тайлангийн үзүүлэлт</b>	<b>2022 оны 12-р сарын 31</b>	<b>2023 оны 12-р сарын 31</b>
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,454,564.40</b>	<b>1,447,648.10</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,029,849.80	1,104,785.60
33	АВЛАГА	343,452.50	261,115.10
35	БАРАА МАТЕРИАЛ	81,262.00	81,747.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,167,369.90</b>	<b>1,507,391.50</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,167,369.90	1,507,391.50
39200	Биет хөрөнгө	1,100,258.50	1,440,927.00
39300	Биет бус хөрөнгө	67,111.40	66,464.60
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,621,934.30</b>	<b>2,955,039.60</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>118,481.10</b>	<b>15,613.60</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	118,481.10	15,613.60
41300	Өглөг	118,481.10	15,613.60
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,503,453.20</b>	<b>2,939,426.00</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,503,453.20	2,939,426.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	351,845.20	351,845.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,921,601.20	2,357,574.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,006.70	230,006.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,621,934.30</b>	<b>2,955,039.60</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,873,384.40</b>	<b>1,924,047.60</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	648,442.20	804,175.90
110	Орлогын албан татвар	147,600.50	178,564.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	147,600.50	190,912.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(12,347.30)
113	Хөрөнгийн албан татвар	29,790.40	37,773.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	471,051.40	587,838.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	217,632.20	347,262.20
120	Нийтлэг татварын бус орлого	217,632.20	347,262.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,007,309.90	772,609.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>875,642.50</b>	<b>1,165,298.10</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,642.50	1,165,298.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	828,600.60	1,142,285.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,331.70	450,152.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,076.60	57,312.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,053.70	33,342.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,949.40	47,935.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,750.00	45,763.10
2107	Томилолт, зочны зардал	9,219.80	16,164.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,187.30	330,730.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,032.20	160,885.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,041.90	23,012.70
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>997,741.80</b>	<b>758,749.50</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,975,969.30</b>	<b>322,776.60</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(2,978,227.50)</b>	<b>435,972.90</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,494,257.00	-	5,494,257.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(12,576.40)	-	(12,576.40)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,481,680.70	-	5,481,680.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	(2,978,227.50)	-	(2,978,227.50)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,453.20	-	2,503,453.20
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,503,453.20</b>	-	<b>2,503,453.20</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,503,453.20</b>	-	<b>2,503,453.20</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	435,972.90	-	435,972.90
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,939,426.00</b>	-	<b>2,939,426.00</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,855,767.60</b>	<b>1,738,999.70</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	648,442.20	804,175.90
110	Орлогын албан татвар	147,600.50	178,564.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	147,600.50	190,912.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(12,347.30)
113	Хөрөнгийн албан татвар	29,790.40	37,773.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	471,051.40	587,838.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,941.30	273,125.00
1181	Газрын төлбөр	33,347.00	139,924.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	432,763.10	174,788.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,015.40	162,214.30
120	Нийтлэг татварын бус орлого	200,015.40	162,214.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,007,309.90	772,609.50
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>750,553.50</b>	<b>1,061,072.10</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,553.50	1,061,072.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,592.10	1,040,514.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,481.70	450,416.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,226.20	57,467.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,053.70	33,342.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,635.60	44,987.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,750.00	45,763.10
2107	Томилолт, зочны зардал	9,219.80	16,164.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,666.70	330,848.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,558.50	61,524.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,961.40	20,557.70
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,105,214.00</b>	<b>677,927.60</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>423,485.00</b>	<b>602,991.80</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	423,485.00	602,991.80
2200	Дотоод эх үүсвэрээр	423,485.00	602,991.80
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(423,485.00)</b>	<b>(602,991.80)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(78,000.00)</b>	<b>-</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,000.00	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>603,729.10</b>	<b>74,935.80</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	426,120.70	1,029,849.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,029,849.80	1,104,785.60

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,009,727.40</b>	<b>1,537,838.60</b>	<b>471,888.80</b>	<b>76.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,281,767.10</b>	<b>1,138,915.66</b>	<b>142,851.44</b>	<b>88.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,260,791.70</b>	<b>1,118,357.96</b>	<b>142,433.74</b>	<b>88.70</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,000.30	449,631.90	13,368.40	97.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,971.60	57,467.09	2,504.51	95.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,399.20	292,422.09	63,977.11	82.05
2104	Хангамж, бараа материалын зардал	44,901.60	42,583.58	2,318.02	94.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,254.80	193,996.42	16,258.38	92.27
2107	Томилолт, зочны зардал	17,466.60	16,164.00	1,302.60	92.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,738.30	11,568.20	13,170.10	46.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,059.30	54,524.68	29,534.62	64.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,975.40</b>	<b>20,557.70</b>	<b>417.70</b>	<b>98.01</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,975.40	20,557.70	417.70	98.01
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>654,847.10</b>	<b>398,922.94</b>	<b>255,924.16</b>	<b>60.92</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>73,113.20</b>	<b>-</b>	<b>73,113.20</b>	<b>-</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,009,727.40</b>	<b>1,707,605.19</b>	<b>302,122.21</b>	<b>84.97</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,389,243.80</b>	<b>1,637,576.00</b>	<b>(248,332.20)</b>	<b>117.88</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>620,483.60</b>	<b>70,029.19</b>	<b>550,454.41</b>	<b>11.29</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	133,951.27	(133,951.27)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	303,717.86	(303,717.86)	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>54.00</b>	<b>54.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>26.00</b>	<b>26.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>26.00</b>	<b>26.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>132,690.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>78,904.58</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		72,439.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		785.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,404.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,014.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		56,935.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>6,464.98</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		6,464.98
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>53,785.69</b>
2200	Дотоод эх үүсвэрээр		53,785.69
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>132,690.27</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		132,690.27

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Түшиг сумын ТТЗ гэх/ нь “Ирээдүй нь гэрэлтэй, Иргэд нь жаргалтай сум болохын төлөө” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Түшиг сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд бие даасан хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагууд хяналт хэрэгжүүлж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Түшиг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 333,105.4 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,029,849.8	1,104,785.6	74,935.8
Авлага	343,452.5	261,115.1	(82,337.4)
Бараа материал	81,262.0	81,747.4	485.4
Үндсэн хөрөнгө	1,167,369.9	1,507,391.5	340,021.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,621,934.2</b>	<b>2,955,039.6</b>	<b>333,105.4</b>
Өр төлбөр	118,481.1	15,613.6	(102,867.5)
Засгийн газрын хувь оролцоо	2,503,453.1	2,939,426.0	435,972.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,621,934.2</b>	<b>2,955,039.6</b>	<b>333,105.4</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,104,785.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 74,935.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,029,849.8</b>	<b>1,104,785.6</b>	<b>74,935.8</b>
<b>Төгрөг</b>	<b>1,029,849.8</b>	<b>1,104,785.6</b>	<b>74,935.8</b>
Төрийн сангийн харилцах	1,029,849.8	1,104,785.6	74,935.8
<b>Дүн</b>	<b>1,029,849.8</b>	<b>1,104,785.6</b>	<b>74,935.8</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 785,581.3 мянган төгрөг ОНЕО-ын дансанд, 230,894.4 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 72,823.4 мянган төгрөг ХХС-ийн дансанд, 15,486.5 мянган төгрөг БХНС барьцаа дансанд тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 261,115.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 82,337.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	149.6	479.0	329.4
Зээлийн хүүгийн авлага	3,027.2	2,565.5	(461.7)
Байгууллагаас авах авлага	146,783.0	102,749.2	(44,033.7)
Хувь хүмүүсээс авах авлага	2,464.4	2,464.4	-
Хувь хүмүүст олгосон зээл	191,028.3	152,857.0	(38,171.4)
<b>Дүн</b>	<b>343,452.5</b>	<b>261,115.1</b>	<b>(82,337.4)</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын 425.4 мянган төгрөг, ИТХ-ын 53.6 мянган төгрөгийн НДШ-ийн авлага,
- Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 23,000.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, сумын ОНХО-ын эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 79,749.2 мянган төгрөгийн наадмын талбайн тохижилтыг тус тус авлагаар бүртгэсэн,
- ОНХО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,464.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч тодорхойгүй/,
- ХХС-ийн зээлийн 152,857.0 мянган төгрөг, зээлийн хүүгийн 2,565.5 мянган төгрөгийн авлага байна.

Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 46,359.7 мянган төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн хүүгийн 1,576.1 мянган төгрөгийн авлага,
- ХХС-ийн зээлийн 44,783.6 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн /2011-2020 оны хооронд зээл авсан/ 70,938.5 мянган төгрөгийн зээлийн авлагаас 26,154.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 81,747.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 485.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Хангамжийн материал</b>	<b>81,262.0</b>	<b>81,747.4</b>	<b>485.3</b>
Аж ахуйн материал	80,392.6	80,392.6	-
Түлш, шатах тослох материал	639.5	1,354.8	<b>715.3</b>
Мал амьтад	230.0	-	<b>(230.0)</b>
<b>Дүн</b>	<b>81,262.0</b>	<b>81,747.4</b>	<b>485.3</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 64,624.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 63,909.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон 230.0 мянган төгрөгийн адууг Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, хорогдлын актыг үндэслэн данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,507,391.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 340,021.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	450,012.2	672,649.6	222,637.5
Авто-тээврийн хэрэгсэл	6,840.1	30,927.2	24,087.1
Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,784.2	102,867.4	14,083.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,640.1	22,535.8	5,895.7
Зам, гүүрийн байгууламж	60,734.6	45,715.3	(15,019.3)
Бусад үндсэн хөрөнгө	477,247.3	566,231.7	88,984.4
Программ хангамж	1,365.6	718.7	(646.9)
Бусад биет бус хөрөнгө	65,745.8	65,745.8	-
<b>Дүн</b>	<b>1,167,369.9</b>	<b>1,507,391.5</b>	<b>340,021.6</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 20,805.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж,
- Төрийн өмчийн барилгын тогтмол зардлын төсвөөс бэлтгэсэн 79,541.6 мянган төгрөгийн Түшиг сумын ЗДТГ-ын барилгыг төвлөрсөн дулаанд холбох ажил,
- Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 49,935.7 мянган төгрөгийн зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг,
- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 52,401.8 мянган төгрөгийн сумын Цагдаагийн хэсэгт автомашин, ЗДТГ-ын архивын өрөөний тохижилт, 2 булгийн эхийг хашаажуулах төсөл, арга хэмжээ,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 192,036.4 мянган төгрөгийн ухаалаг гүний худаг, тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн талбайн

тохижилт, гудамжны камержуулалт зэрэг төсөл, арга хэмжээг тус тус комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгаснаас шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 15,613.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 102,867.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	118,481.1	15,613.6	(102,867.5)
<b>Дүн</b>	<b>118,481.1</b>	<b>15,613.6</b>	<b>(102,867.5)</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагыг авсан, БХНС барьцаа дансанд тайлант онд 853.9 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан зэргээс голлон шалтгаалсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,939,426.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 435,972.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	351,845.2	351,845.2	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,921,601.2</b>	<b>2,357,574.1</b>	<b>435,972.9</b>
Өмнөх үеийн үр дүн	4,899,828.7	1,921,601.2	(2,978,227.5)
Тайлант үеийн үр дүн	(2,978,227.5)	435,972.9	3,414,200.4
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>230,006.7</b>	<b>230,006.7</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>2,503,453.1</b>	<b>2,939,426.0</b>	<b>435,972.9</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Түшиг сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 89 дүгээр тогтоолоор тайлант онд 427,836.6 мянган төгрөгийн татварын орлого,

16,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **443,836.6** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **965,536.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.1 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

<i>/мянган төгрөг/</i>				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>427,836.6</b>	<b>804,175.9</b>	<b>376,339.3</b>	<b>188.0</b>
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	166,087.1	174,891.5	8,804.4	105.3
Үйл ажиллагааны орлого	4,400.0	4,107.6	(292.4)	93.4
Хөрөнгийн орлого	9,000.0	10,857.0	1,857.0	120.6
Хөрөнгө борлуулсны орлого	6,000.0	1,056.0	(4,944.0)	17.6
ХХОАТ-ын буцаалт	(16,000.0)	(12,347.3)	3,652.7	77.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	30,000.0	2,835.7	(27,164.3)	9.5
Бууны албан татвар	1,500.0	2,450.0	950.0	163.3
Малд ногдуулах албан татвар	68,273.5	32,487.5	(35,786.0)	47.6
Улсын тэмдэгтийн хураамж	4,000.0	3,094.9	(905.1)	77.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	269,730.0	269,230.0	53.9 дах
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	300.0	(1,700.0)	15.0
Газрын төлбөр	9,264.0	29,141.4	19,877.4	314.6
Дуудлага худалдаа	26,981.0	110,782.9	83,801.9	410.6
Ойн нөөц ашигласны төлбөр	113,191.0	170,465.8	57,274.8	150.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	720.0	1,434.4	714.4	199.2
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,920.0	2,888.5	968.5	150.4
<b>Татварын бус орлого</b>	<b>16,000.0</b>	<b>161,360.3</b>	<b>145,360.3</b>	<b>1,008.5</b>
Торгуулийн орлого	10,000.0	16,731.0	6,731.0	167.3
Түрээсийн орлого	2,500.0	1,677.3	(822.7)	67.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	500.0	70,029.2	69,529.2	14,005.8
Бусад орлого	3,000.0	72,922.8	69,922.8	24.3 дах
<b>Нийт орлогын дүн</b>	<b>443,836.6</b>	<b>965,536.2</b>	<b>521,699.6</b>	<b>217.5</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр гүйцэтгэлээр 269,730.0 мянган төгрөг төвлөрсөн, газрын дуудлага худалдааны орлого 83,801.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Давж биелсэн орлогууд:**

- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого:** “Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл 2 хэсэг” тайлант онд Түшиг сумын нутагт авто замын ажил явагдаж, замын хучилт, далангийн ажилд хэрэглэгдэх хайрга ашигласны төлбөрт 269,730.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 269,230.0 мянган төгрөгөөр давсан,

- **Газрын дуудлага худалдааны орлого:** Тайлант онд сумын 13 байршилд газрын дуудлага худалдааг явуулж, 3 дуудлага худалдааны ялагч үнийг төлөөгүй гэсэн үндэслэлээр хүчингүй болж, 10 газрын дуудлага худалдааны 110,782.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, 83,801.9 мянган төгрөгөөр давсан,
- **Ойн нөөц ашигласны төлбөр:** Ойгоос бэлтгэх модны хуваарийн дагуу Түшиг сумын иргэд, нөхөрлөл, 4 аж ахуйн нэгжийн мод бэлтгэл, Зүүнбүрэн, Сүхбаатар сумын иргэн, аж ахуйн нэгжийн түлээний модны эрхийн бичгийн 170,465.8 мянган төгрөгийн орлого төвлөрч, 57,274.8 мянган төгрөгөөр давсан,
- **Бусад орлого:** Тус суманд авто замын ажил гүйцэтгэж буй “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ийн байгаль орчинд учруулсан хохиролд тавигдсан нөхөн төлбөрийн актаар 69,676.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь голлон нөлөөлж, 69,922.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

#### Тасарсан орлого:

- **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:** Үндэслэлгүй төлөвлөлт буюу Сангийн яамнаас төлөвлөгөөг хэт өндрөөр тавьж өгснөөс тайлант онд 2,835.7 мянган төгрөгийн орлого төвлөрч, 27,164.3 мянган төгрөгөөр тасарсан,
- **Малд ногдуулах албан татвар:** Тус суманд татварын улсын байцаагч 2023 оны 11 дүгээр сард томилогдсон, тайлант хугацаанд төлбөрийн нэхэмжлэх үүсгээгүйгээс сумын малчин болон мал бүхий иргэдийн төлбөр төлөлт хангалтгүй болж, 32,487.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 35,786.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 835,418.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 595,221.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 241,769.3 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 438,249.5 мянган төгрөг, өөрийн орлогыг 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 544,649.9 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 75,333.2 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг 1,895,722.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгож, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 52,142.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

Эх үүсвэрийг 61,862.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж: *Аймгийн дэмжлэгийн нэмэгдэл дээр нэмж баталсан /*

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 5,087.1 мянган төгрөгөөр,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 56,774.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,

Зарлагыг 114,004.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Сумын ОНХС-ийн зардлыг 56,774.4 мянган төгрөгөөр,
- Сумын ЗДТГ-ын цалингийн зардлыг 50,838.0 мянган төгрөгөөр,
- Сумын ИТХ-ын цалингийн зардлыг 6,392.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,009,727.4** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,281,767.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 654,847.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 73,113.2 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 647,363.5 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 443,836.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 75,333.2 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 298,543.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 544,650.4 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:*

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	137,779.6	94,259.1	43,520.5	68.4
2	Засаг даргын тамгын газар	965,305.2	857,726.9	107,578.3	88.9
3	Орон нутгийн хөгжлийн сан	453,847.1	266,771.9	187,075.2	
4	Хоршоо хөгжүүлэх сан	75,333.2	100.0	75,233.2	0.1
5	ЕБС	173,216.5	164,025.7	9,190.8	94.7
6	Эрүүл мэндийн төв	64,198.6	44,144.8	20,053.8	68.8
7	Цэцэрлэг	73,776.7	64,589.1	9,187.6	87.5
8	Соёлын төв	66,270.5	46,221.1	20,049.4	69.7
	<b>Нийт дүн</b>	<b>2,009,727.4</b>	<b>1,537,838.6</b>	<b>471,888.8</b>	<b>76.5</b>

*Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 445,097.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 893,935.3 мянган төгрөг, өөрийн орлогоос 70,029.2 мянган төгрөг, ОНХС-аас 298,543.7 мянган төгрөг нийт **1,707,605.2** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,537,838.6** мянган төгрөг буюу 76.5 хувьтай байгаа нь урсгал зардлыг 142,851.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 255,924.2 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 73,113.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 15,872.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 63,977.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,468.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 16,258.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 1,302.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 13,020.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 471.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 29,534.6 мянган төгрөгөөр зэрэг нийт 142,851.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 14 төсөл, арга хэмжээнд 654,847.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 398,922.9 мянган төгрөг олгож, 255,924.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ХХС-аас 73,113.2 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч зээл олгоогүйгээс хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 17,154.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 9,259.9 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 300.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас 600.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 1,199.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 104,176.4 мянган төгрөг зэрэг нийт 132,690.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг 5 хөтөлбөрийн 6 арга хэмжээний дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 785.0 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 2,404.1 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 12,014.8 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 300.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 56,935.7 мянган төгрөг,
- Хөрөнгийн зардалд *Аймгийн ОНХО-ын шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЭМТ-ийн өргөтгөлийн их засвар* 53,785.7 мянган төгрөг зэрэг нийт 126,225.3 мянган төгрөгийг зарцуулж, 6,465.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС, ОНХО, урсгал зардлын төсвөөс 742,004.0 мянган төгрөгийн 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар гүйцэтгэх 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Түшиг сумын 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан:

*/мянган төгрөгөөр/*

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			ШХА		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	2	191,774.4			2	191,774.4		
Сумын ОНХС	3	204,769.3			3	204,769.3		
Урсгал зардал	1	79,900.0			1	79,900.0		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>476,443.7</b>			<b>6</b>	<b>476,443.7</b>		

*Эх сурвалж: tender.gov.mn*

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөрөнгийн тооллого, төсвийн төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн 2/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 875,642.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,756.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,165,298.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11,653.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй,
- Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулаагүй,
- Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал*

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	176	2
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	178	4
3	Сумын Засаг даргын Тамгын газар	182	181	1
	<b>Нийт дүн</b>	<b>542</b>	<b>535</b>	<b>7</b>

*Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)*

1. Тайлант хугацаанд Түшиг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 542 мэдээллээс 535 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “ ... хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... нь тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж заасныг үндэслэн төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Түшиг сумын Засаг дарга Г.Батболд, ЗДТГ-ын дарга Б.Уранчимэг нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ТБОНӨХБАУХА тухай хуулийн нийцэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сумын ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **20,728.8** мянган төгрөгийн эд хогшил худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1. *Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг*, 2. *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

2. “Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ” ААТҮГ нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, сумын ИТХ, Засаг даргаар батлуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудас хөтлөлт, худалдан авах ажиллагаа, орон нутгийн өмчит газрын үйл ажиллагаа нь Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, ТБОНӨХБАУХА тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 89,948.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 171,667.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөгдсөнөөс “*шатахуун зарцуулалтын гүйцэтгэлийг*

жолоочийн тооцооны хуудсаар хянаж, анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх” гэсэн 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	8	89,948.5	8	89,948.5	100
Зөвлөмж	5	171,667.9	4	141,045.0	80
<b>Нийт дүн</b>	<b>13</b>	<b>261,616.4</b>	<b>12</b>	<b>230,993.5</b>	<b>92.3</b>

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. “Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын төсөл”-ийн гүйцэтгэгч “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-иас түгээмэл тархацтай ашигт малтмал бэлтгэсэн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах 15,486.5 мянган төгрөгийг БХНС барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Хайрга чулуу олборлох, ашиглах үйл ажиллагааг дуусмагц нөхөн сэргээлт хийсэн талбайг актаар хүлээлгэн өгсөн эсэх, барьцаа хөрөнгийг буцаан олгосон эсэхийг дараагийн аудитаар шалгах шаардлагатай.

2. ЗДТГ-ын төсөвт батлагдаагүй орон тоо буюу Хэвлэл мэдээллийн ажилтнаар Б.Энэрэлийг томилон ажиллуулсан байна.

Иймд “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар цаашид гүнзгийрүүлэн авч үзэх нь зүйтэй юм.

3. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 79,749.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

### **Залруулаагүй алдаа:**

- Сумын ОНХО-ын эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 79,749.2 мянган төгрөгийн Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Наадмын талбай/ төсөл, арга хэмжээг бусад хангамжийн материал дансанд бус авлагаар бүртгэсэн.

Өгсөн зөвлөмж: Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг 2024 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **123,679.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **1,480.5** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **33,013.8** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **89,185.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгах **3** зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт:**

#### **Сумын ЗДТГ:**

1. Албан хаагчдын цалин, нэмэгдлийг **1,280.5** мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон байна. Үүнд:

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч Н.Гантогтоход байгаль орчны мэргэжилтний албан тушаалыг хавсран ажилласны нэмэгдлийг үндсэн цалингаас 40 хувиар тооцож, 352.0 мянган төгрөг илүү олгосон,
- Санхүүгийн албаны дарга Б.Батдэлгэрт төрийн сангийн мэргэжилтний албан тушаалыг хавсран ажилласны нэмэгдлийг үндсэн цалингаас 40 хувиар тооцож, 96.0 мянган төгрөг илүү олгосон,
- Хөдөө аж ахуйн тасгийн дарга Э.Учралд тооцооллын алдааны улмаас 832.5 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “... бусад төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ний “ТЗ-9: 791,532”, 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “... байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ний “ТЗ-9 : 1,100,000” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## Сумын ИТХ:

2. “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Ариунжаргалд **200.0** мянган төгрөгийн мөнгөн шагналыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.7 дахь “*Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй.*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон мөнгөн шагналыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага:

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас сумын ЗДТГ 53.6 мянган төгрөг, ИТХ 425.4 мянган төгрөг нийт **479.0** мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Батлагдсан төсвийг зардлын бүлэг, арга хэмжээ хооронд гүйлгэн, **6,479.7** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

## Сумын ЗДТГ:

- Сумын Засаг даргын 2023 оны Б/06 захирамжаар “Тэргүүний сум”-аар шалгарсан үндэслэлээр 17 албан хаагчид 2,862.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас, 6 албан хаагчид 540.0 мянган төгрөгийн урамшууллыг ЗДНХ-ийн төсвөөс, аймгийн Засаг даргын захирамжаар сумын Засаг дарга Г.Батболдод 841.7 мянган төгрөгийн нийт **4,243.7** мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас тооцож олгосон,

## Сумын ИТХ:

- Бараа үйлчилгээний бусад зардлаас **1,736.0** мянган төгрөгийн албан томилолтын зардал гаргасан,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас иргэнээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхэд зориулж, **500.0** мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган, төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс дараах **3,655.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Гадаад албан томилолтын зардалд 1,905.0 мянган төгрөгийг тооцож олгосон,
- ЗДҮАХХ-ийн зардлын 1,750.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг тус хөрөнгийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1 дэх “Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна: 3.1.2: урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал ... ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Сумын ОНХО-ын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Наадмын талбай/ ажлыг гүйцэтгэж дуусаагүй, комиссын акт гараагүй байхад гүйцэтгэгч Баян өндөр булаг ХХК-д гэрээний заалт зөрчин **15,075.1** мянган төгрөгийн санхүүжилтийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний “Санхүүжилтийн хуваарь”-ийн “Ажлыг бүрэн хүлээлгэн өгснөөр үлдэгдэл санхүүжилт 23,674.1 мянган төгрөгийг олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний заалтыг мөрдөж ажиллах, хүлээж авсан комиссын шийдвэрийг үндэслэн үлдэгдэл төлбөрийг шилжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

5. Сумын ОНХС-ийн батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний **7,325.0** мянган төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр тооцож, олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.6 дахь “Төсөл, арга хэмжээний ... эцсийн санхүүжилтийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын дүгнэлт гарсны дараа олгох бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж, ... ирүүлнэ: 4.3.6.12:магадалшгүй ажил гарсан бол оролцогч талуудын шийдвэрлэсэн хурлын тэмдэглэл” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Магадалшгүй ажлын зардлыг холбогдох журмын дагуу тооцож олгож байх албан шаардлага хүргүүлэв.

**6.** Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс сумын ЗДТГ, ИТХ-ын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хуучин тээврийн хэрэгслүүдийн насжилт, элэгдэл зэргийг тооцон, 100 км гүйлтэд зарцуулах шатахуунд хэмжилт, туршилт явуулж, бодит нормыг тогтоолгүйгээр жишиг нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 3 дугаар хавсралтаар баталсан “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж”-ийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтад хэмжилт, туршилт хийсний үндсэн дээр нормыг тогтоож, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж мөрдөх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөв.

## **2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Аж ахуйн нэгж, байгууллагуудтай жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулж байх зөвлөмж өгөв.

## **3. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Зайлшгүй гарах зардлыг төсөвт тусгаагүй буюу төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөөгүйгээс **зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал** хооронд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- “Түшиг сумын ЗДТГ-ын барилгыг төвлөрсөн дулаанд холбох ажил” **79,900.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй **хөрөнгө оруулалтын шинж чанартай зарлагыг** төсвийн **урсгал зардалд** буюу Төрийн өмчийн барилгын тогтмол зардлын арга хэмжээний урсгал засварын төсөвт баталж, хэрэгжүүлсэн,
- Сумын ОНХО-ын эх үүсвэрт “Тусгай автомашины тоноглол” **8,000.0** мянган төгрөгийн өртөгтэй урсгал зардлыг тусгаж, хэрэгжүүлсэн,
- Сумын ЗДТГ-ын төрийн өмчийн барилгын тогтмол зардлын */80111/* арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай */80101/* холбоотой гарах тээврийн хэрэгслийн сэлбэг, дугуй, тос тосолгоо, засвар үйлчилгээний зардалд **1,285.0** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “*Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална*”: 5.1.2: “*Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ын “*80101: Үндсэн үйл ажиллагааны зардал*”, “*80111: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан

“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 21-Урсгал зардал<sup>1</sup>, 210604-Урсгал засвар<sup>2</sup>, 22-Хөрөнгийн зардал<sup>3</sup> гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зардлыг холбогдох арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг ханган ажиллах зөвлөмж өгөв.

**Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>4</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> 21-Урсгал зардал-Тухайн тайлант жилд байгууллагын болон хөтөлбөр, арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах жил бүр давтагддаг урсгал шинжтэй зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

<sup>2</sup> 210604-Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна.

<sup>3</sup> 22-Хөрөнгийн зардал-Тухайн төсвийн жилд төсвийн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө бий болгох, барилга, байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламжид их засвар хийх, стратегийн шинжтэй бараа, бүтээгдэхүүнийг улсын нөөцөд байршуулахтай холбоотой зарцуулах зардлууд энд багтана.

<sup>4</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Түшиг сумын ТТЗ	1	79,749.2			1	79,749.2			1	79,749.2	1	79,749.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>79,749.2</b>			<b>1</b>	<b>79,749.2</b>			<b>1</b>	<b>79,749.2</b>	<b>1</b>	<b>79,749.2</b>

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түшиг сумын ТТЗ	9	123,679.3	1	1,480.5	4	33,013.8	3	89,185.0	1	1	1	1
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>123,679.3</b>	<b>1</b>	<b>1,480.5</b>	<b>4</b>	<b>33,013.8</b>	<b>3</b>	<b>89,185.0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс	
		Төлбөрийн акт	Албан шаардлага

/мянган төгрөгөөр/

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Түшиг сумын ТТЗ	1	20,728.8			1	20,728.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>20,728.8</b>	-	-	<b>1</b>	<b>20,728.8</b>		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>20,728.8</b>	-	-	<b>1</b>	<b>20,728.8</b>		